

МОНГОЛ УЛСЫН ГЕОПОЛИТИК, ГЕОЭДИЙН ЗАСГИЙН БАЙР СУУРИЙН ТУХАЙ ШИНЖИЛГЭЭ

Б.Хөгжилт*

***Abstract:** This article discusses about the China-Mongolia-Russia trilateral relationships and the practical course of international relations from the perspective of geopolitics and geo-economy. Based on time and the changes of condition, the paper also makes an analysis on the geopolitical and geo-economic status of Mongolia on both theoretical and practical level. The findings show that: Mongolia is a: 1. buffer zone or strategic space; 2. geopolitical pivot area or bridgehead; 3. landlocked country; 4. newly emerging nation of resource provider; 5. convenient logistical and road-bridge channel.*

Key words: Mongolia Geopolitics, Geo-Economics, Position, Analysis

* * *

Монгол Улс нь монголын өндөрлөгийн дунд байрлаж, байгалийн газарзүй болон түүхийн газарзүйн хуваарилалд, Төв Ази буюу Хойд Азид хамрагдаж, улс төрийн газарзүйн хуваарилалд Зүүн Ази буюу Зүүн Хойд Азид хамрагдана. Монгол Улсын нутаг дэвсгэр хэвтээ чиглэлд хамгийн уртдаа 2368 км, босоо чиглэлд хамгийн уртдаа 1260 км, нийт талбай 1,564,100 квадрат км байж, дэлхийд 18-рт эрэмбэлэгдэж байна.

Монгол Улсын хилийн шугамын нийт урт 8219 км, зүүн, өмнө, баруун талаар БНХАУ-тай хил залгаж, Монгол-Хятадын хилийн шугамын урт 4676.8 км, Хятадын 14 хөршөөс хамгийн урт бөгөөд төв бүсээс хамгийн ойр хилийн шугам бүхий улс мөн. Умард талаар ОХУ-тай залгаж, Монгол-Оросын хилийн шугамын урт 3543 км байна. 2015 оны 1-р сарын эхээр Монгол Улсын хүн амын тоо 3 саяд хүрсэн ба хүн ам багатай, газар нутаг ихтэй улс юм.

Монгол Улс нь далайд гарцгүй улс бөгөөд хоёр хөрш нь дэлхийн хэмжээний том гүрэн учир энэ нь аль ч орноос ялгарах цорын ганц геополитик, гео-эдийн засгийн онцлог нөхцөл мөн. Энэхүү нөхцөл болон Монгол Улсын даяаршил, бүс нутгийн интеграцид нэгдэх үйл явц, чадавхи нь Монгол Улсын гадаад бодлогын чиг хандлагыг тодорхойлж, түүний олон улсын харилцаан дахь байр суурь, үүрэг роль хийгээд хөгжлийн хэтийн төлөвд нөлөөлдөг.

Монгол Улсын гадаад бодлогын түүхэн замналаас үзэхэд, хүйтэн дайны үед түүний гадаад бодлого бүхэлдээ ЗХУ-аар толгойлсон социализмын лагераас хамааралтай байж, Хятад-Зөвлөлтийн харилцаа сайн байхын хэрээр Хятад-Монголын харилцаа сайн байж, Хятад-Зөвлөлтийн харилцаа муудахын хэрээр Монгол Улс Зөвлөлтийн талыг барин, улс төр, цэргийн хувьд “Варшавын гэрээний” байгууллагаас хамааран, эдийн засгийн хувьд ЭЗХТЗ-д нэгдэж, өмнөд хөрштэйгээ

* ӨМИС-ийн Монгол Улсыг судлах хүрээлэнгийн Ахлах судлаач, Доктор (Ph.D)

харилцаа муу байсан нь Монгол Улсын геополитикийн гадаад орчноос ихээхэн хамааралтай байхын түүхэн сургамж юм.

Хүйтэн дайны төгсгөл нь Монгол Улсад өөрийн геополитик, гео-эдийн засгийн онцлогт нийцсэн биеэ даасан дотоод гадаад бодлого боловсруулж хэрэгжүүлэх, олон улсын нийгэмлэгт ойртон нэгдэх урьд өмнө байгаагүй гадаад орчныг хангав. Ийнхүү Монгол Улс нь өөрийн геополитик, гео-эдийн засгийн онцлог болон түүхэн сургамжид тулгуурлан, хоёр хөршийн харилцааг тэргүүлэх чиглэлд тавьсан ба тэнцвэртэй, олон тулгуурт, эвсэлд үл нэгдэх, цөмийн зэвсэггүй статус бүхий гадаад бодлого боловсруулж хэрэгжүүлэхийн хамт, өрнийн том гүрэн болон нэр нөлөө бүхий олон улсын байгууллагын ашиг сонирхлыг бий болгон, түүгээр дамжуулан хоёр хөршийн хэт нөлөөг хянаж хумих, улс орны эрх ашгаа нэмэгдүүлэх зорилт бүхий “гуравдагч хөрш”-ийн бодлого явуулж, олон улсын харилцаанд идэвхтэй оролцсоноос, олон улс дахь байр суурь нь дээшилсэн байна. Үүнээс үзэхэд, геополитикийн хувьд Монгол Улс бол хоёр хөрш болон бүс нутгийн жийргэвч бүс, стратегийн орон зай байж болох хэдий ч зарим тохиолдолд түшиц газар нь ч байж болох юм. Харин хоёр хөрштэй нь өрсөлдөх, дайсгалцах дэлхийн буюу бүс нутгийн том гүрний хувьд, Монгол нь Хятад, Оросыг хянаж хумих зангилаа бүс буюу түшиц газар нь байж болно.

Гео-эдийн засгийн хувьд Монгол Улс бол нэг уламжлалт мал аж ахуйд суурилсан, зах зээлийн багтаамж бага, гадаадтай харилцах эдийн засгийн зардал ихтэй, тодорхой бус эрсдэлүүд олонтой, хоёр хөршдөө гүн түшиглэсэн, далайн гарцгүй, зах зээлээс амархан орхигдох улс юм. Гэхдээ эдийн засгийн даяаршил, бүс нутгийн интеграцийн хөгжил, олон улсын харилцаанд ардчилал, бүх нийтийн үнэт зүйлсийг улам бүр чухалчлах болсон нь, ялангуяа Монгол Улсын асар их эрдэс баялгийн нөөцийн удаа дараагийн илрүүлт нь түүний гео-эдийн засгийн байр суурийг эрс дээшлүүлж, тэдгээрийн хэрэгцээний том гүрэн болон уул уурхайн үндэстэн дамнасан компаниудын анхаарлыг ихээр татсан байна. Тэрчлэн дэлхийн хуурай зам тээврийн инноваци технологи нь хоёрдогч байранд байсан “эх газрын гүүр”-ийн эдийн засаг, стратегийн ач холбогдолыг шинэ түвшинд өндөржүүлж, дэлхийн хэмжээнд геополитик, гео-эдийн засгийн шинэ байрлуулалт, нэгдлийн үйл явцыг үүсгэж байна. Иймэрхүү нөхцөл байдалд Монгол Улсын Хятад, Оросын хооронд орших орон байрын хүчин зүйлд шинэ агуулга өгөгдөн, Хятад-Монгол-Оросын гурамсан харилцаа улам бүр ойр дотно болж, гурван орны төрийн тэргүүний уулзалтын механизм төлөвшин тогтож, гурван орны стратегийг уялдуулсан “эдийн засгийн коридор” нэгэнт төлөвлөлтийн шатанд хэрэгжиж байна. Ийнхүү Монгол Улсын геополитик, гео-эдийн засгийн байр суурьд доорх дүгнэлтийг дэвшүүлж байна.

1. Жийргэвч бүс буюу стратегийн орон зай

Энэ бол хоёр хөрш болон бүс нутгийн хувь дахь Монгол Улсын геополитикийн онцлогийн нэг юм. Үүнд газар зүй болон улс төр гэсэн хоёр түвшний агуулга хамрагдана. Газар зүйн хувьд Монгол нь ихэвчлэн хэвтээ босоо чиглэлийн орон

зайд Хятад, Оросын чухал бүс болох Хятадын Умард бүс болон Оросын Сибирийн бүсийг тусгаарлаж, тэдгээрийн өөр хоорондын хүч хэрэглэх тухай эмзэглэл, хардлага, үл итгэлцэх байдлыг багасгаж, цаашлаад хүч хэрэглэх стратеги, эдийн засгийн зардлыг тэр хэрээр нэмэгдүүлж, ямар ч цаг үед энэхүү газар зүйн буфер үүргээ гүйцэтгэсээр ирсэн. Түүхээс харахад, хардлага, үл итгэлцэл, ташаа магадлалаас болсон гэнэтийн дайралтын жишээ бага бус юм. Ялангуяа Хятад, Оросын хүчний тэнцвэр алдагдаж, геополитикийн ашиг сонирхлын зөрчил, маргаан хурцадсан нөхцөл байдалд иймэрхүү буфер үүргийг тооцохгүй байж болохгүй.

Улс төрийн хувьд Монгол Улс 1990 оноос эхлэн эвсэлд үл нэгдэх, төвийг сахисан, цөмийн зэвсэггүй статус бүхий гадаад бодлого хэрэгжүүлж байгаа нь хоёр хөрш болон бүс нутагт чухал буфер үүрэг гүйцэтгэж байгаа юм. Тус бодлогын хүрээнд дотоод бодлогын баримт бичиг, хоёр талт болон олон талт хэлэлцээрээр баталгаажуулсан аль нэг талтай нь эвсэж, нөгөө талтай нь дайсагналцахгүй, гуравдагч орны цэргийн байгууламж, баазыг байрлуулахгүй, нутаг дэвсгэрээр гадаад орны цөмийн зэвсгийг дамжин өнгөрөөхгүй, улс орны амин чухал ашиг сонирхолд хамаагүй хоёр хөршийн хэрэг явдалд төвийг сахих, өөрийн нутаг дэвсгэрт хоёр хөршид хохирол учруулахуйц үйл ажиллагааг хориглох зэрэг бодлого нь хоёр хөрш болон бүс нутгийн аюулгүй, тогтвортой байдалд чухал буфер үүргийн хэв загварыг бий болгосон байна.

Монгол Улс нь ОХУ-ын Сибирийн цэрэг, аж үйлдвэрийн бааз, Транс-Сибирийн төмөр зам ба Сибирь-Алс Дорнодын эрчим хүчний дамжуулах шугам хоолойн өмнө талд байрлаж, ямар ч цаг үед Оросын Алс Дорнодын болон Ази-Номхон далайн бодлогын чухал өмнөд халхавч болон агшиж сунаж болохуйц стратегийн орон зай юм. Монгол Улсын тусгаар тогтнолын олон улсын эрх зүйн чухал үндэслэл болох “Ялтын хэлэлцээр”-г баталгаажуулж хэрэгжүүлэхэд Сталины оруулсан хүчин цармайлтын гүн утга нь энд байгаа юм.

Хятадын хувьд Монгол Улсын буфер ач холбогдол нь Оросынхоос яасан ч дооргүй юм. Хятад бол далай хуурайн нийлмэл улс бөгөөд аюулгүй байдлын аюул заналхийлэл далай болон хуурайн аль алинаас ирж болох ч, түүхэн хугацаанд голдуу эх газраас ирж байсан бөгөөд сүүлийн үед далайгаас ирэх нь давамгайлах болов. Хятад Монголын газарзүйн байршил буюу Хятадын 22,000 км урт хуурай газрын хилийн шугамд Хятад-Монголын хилийн шугам 1/5-г эзэлж, хилийн шугамаас 700 км нумын хэлбэрийн зайд Хятадын “гурван умард бүс”-ийн гол гол улс төр, эдийн засаг, соёлын төв, сансрын бааз, цөмийн туршилтын баазууд хамрагдахаас Монгол Улс нь Хятадын аюулгүй байдлын чухал умард халхавч бөгөөд баруун, умард зүгт хөгжих боломжийг батлах стратегийн орон зай юм.

Олон улсын харилцааны онол болон арга хэрэгслийн шинэ ололт амжилт, даяаршил болон бүс нутгийн интеграцийн хөгжлийг даган, буфер үүргийн агуулга ба цар хүрээ нь ч улам баяжин тэлж байна. Шилжилтийн эхний үеэс Монгол Улс нь өөрийн цөмийн зэвсэггүй бүсийн статусаа зарлан, НҮБ-ын Ерөнхий Ассамблей

болон аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн орноор баталгаажуулан, ЗХА-ийн аюулгүй байдлын талаарх “Улаанбаатарын яриа хэлэлцээний механизм”-ын санаачилга дэвшүүлж, өөрийн бүс нутаг дахь Япон, Солонгос, Хойд Солонгостой сайн харилцаатай байдаг давуу талдаа суурилсан идэвхтэй үйл ажиллагаа хүчин цармайлт хийж, ЗХА-ийн аюулгүй, тогтвортой байдал, Солонгос хойгийн асуудлыг түлхэн ахиулахад өөрийн гэсэн тодорхой хувь нэмрээ оруулсаар байна.

Улс төр, цэргийн хувь дахь буфер байр суурь, үүрэг роль нь хувиршгүй мөнхийн юм биш. Тэр нь Монгол Улсын гадаад бодлого нь гадаад орчноос ихээхэн хамааралтайн хэрээр гадаад орчны нөхцөл байдлын өөрчлөлтөөс шалтгаалан өөрчлөлт үүсэх боломж ч бий. Монгол Улс нь хоёр хөрш Хятад, Оростой харьцуулахад, дэндүү бага учир Хятад Оросын хүчний тэнцвэр алдагдаж, геополитикийн зөрчил, маргаан хурцдах, эвлэршгүй болох буюу бүс нутаг, олон улсын дэглэмд эрс өөрчлөлт гарах тохиолдолд Монгол Улсын эвсэлд үл нэгдэх, тэнцвэртэй, төвийг сахих бодлогын гадаад нөхцөл алдагдаж, гадаад бодлогын үзэл баримтлалдаа өөрчлөлт оруулах шаардлага үүсэх, цаашлаад түүхэн цаг хугацаанд нэг талыг барьж байсан, эвсэлд нэгдэж байсан зэрэгт буцаж очих магадлал онолын хувьд байгааг ч үгүйсгэхийн аргагүй юм.

Ийм үйл явц үүсвэл бүс нутгийн улс орнуудын хүчний тэнцвэрийг алдагдуулж, бүс нутгийн энх тайван болон хөгжлийн нийтлэг эрх ашигт нийцэхгүй нь дамжиггүй. Түүнчлэн үүнийг Монголын сонголт гэхийн зэрэгцээ гадаад орчны өөрчлөлтөөс болсон албадан тулгалт гэж үзэх ёстой. Хэрэв яахын аргагүй энэхүү байдал үүсвэл, Монгол Улс нь геополитикийн хувьд өнөөх хамаарлын том гүрэн буюу бүлэглэлийн геополитикийн зангилаа бүс цаашдаад түшиц газар болох магадлал эрс нэмэгдэнэ.

2. Геополитикийн зангилаа бүс буюу түшиц газар

Геополитикийн зангилаа бүс буюу улсын тухай, АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын зөвлөх асан, алдарт геополитикч З.Бжезинскийн томоохон бүтээл “Их шатар-АНУ-ын тэргүүлэх байр суурь түүний гео-стратегий” номд “геополитикийн зангилаа /fulcrum/ улс” гэсэн нэр томъёоллоор гүнзгий хураангуйлсан байдаг. Түүний үзсэнээр “геополитикийн зангилаа улс” гэсэн ойлголтод даарах үндсэн агуулга багтана: (1) Эмзэг газар зүйн байршил, түүний эмзэг байдлын талаарх байдал нь гео-стратегийн тоглогчдын үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх. (2) Гео-стратегийн тоглогч чухал бүс нутагт орох буюу ямар нэгэн нөөц олж авах эсэхийг шийдвэрлэх. (3) Ямар нэгэн улс цаашлаад бүс нутгийн хамгаалалтын чухал халхавч болох. (4) Ямар нэгэн зэргэлдээх гео-стратегийн тоглогчид улс төр, соёлын томоохон нөлөө үзүүлэх гэх мэт.²⁴

“Геополитикийн зангилаа улс”-ын онцгой газар зүйн байрлал, үүрэг роль нь түүний олон улсын харилцаан дахь онцгой байр суурийг тодорхойлж, гео-

²⁴ З.Бжезинский, “Их шатар-АНУ-ын тэргүүлэх байр суурь түүний гео-стратегий” [The Grand chessboard: American Primacy and its Geostrategic Imperatives], БНХАУ-ын ОУХ орчуулав, Шанхай-н ардын хэвлэлийн хороо, 1998 он.

стратегийн тоглогчдын өрсөлдөн ойртох, нэвчих зорилтот орон болдог байна. Хэрэв “геополитикийн зангилаа улс” нь үнэхээр гео-стратегийн тоглогч том гүрний нэвчсэн буюу хамааралтай орон болбол, нэг талаар нэвчсэн том гүрэнд дараах эрх ашгийг бий болгоно: (1) Нэвчсэн улсын зангилаа улс дахь улс төр, эдийн засаг, соёлын ашиг сонирхлыг хангах, зангилаа улсаар бааз болгон, хөрш орнуудад “үлгэр жишээний нөлөө” үзүүлэх. (2) Бүс нутгийн уламжлалт том гүрний нөлөөг хязгаарлах, шахан гаргах, өөрт нь ашигтай бүс нутгийн хүчний тэнцвэрийг бий болгох²⁵ гэх мэт.

Монгол Улсын геополитикийн зангилаа буюу түшиц газрын тухай Америкийн судлаач, улстөрчдийн нэлээд оноосон дүрслэлүүд байдаг. Жишээлбэл, “бахө”, “шаантаг”, “үлгэр жишээний үйлдэл” гэх мэт, эдгээрийн ерөнхий утга нь: Монгол бол Орос болон Хятадын хооронд байгаа “бахө”, “шаантаг” байж, хоёулыг хамтад нь хянан хумиж болох зангилаа, Монгол бол Азийн ардчиллын загвар байж, түүгээр дамжуулан хөрш зэргэлдээ орнуудад “үлгэр жишээний үйлдэл” үзүүлэх гэх мэт болно.

Өнгөрсөн Хятад-Зөвлөлтийн харилцаа муу, Хятад-Монголын харилцаа муу байсан үед Зөвлөлт нь Монголд цэргийн бааз байгуулж, Монгол нь Зөвлөлтөөс Хятадыг заналхийлэх, бүх салбарт нөлөө үзүүлэх чухал түшиц газар байсан түүхтэй. Гэхдээ энэ нь Монголын хувьд геополитикийн хүчний байдлаас улбаалсан аргагүйн хувь тавилан. Ардчилалд шилжснээс хойших Монголын хэрэгжүүлж байгаа гадаад бодлого нь бүс нутгийн энх тайван болон аюулгүй байдалд нааштай нөлөө үзүүлснийг дээр дурдсан.

Үүний хамт Монголын хэрэгжүүлж байгаа “гуравдагч хөрш”-ийн бодлого нь Америкийн бүх бөмбөрцгийн стратегийн хоёр их өрсөлдөгч-Орос, Хятадыг ойр хавиас хамтад нь хянан хумих бодлогод боломжийн орон зай бөгөөд Монгол, Америкийн харилцаа эрчимжихийн хэрээр Америкаас Монголыг өөрийн “нөлөө”-ний орон болгох гэсэн оролдлого ер нь тасраагүй. Хэрэв ЗХА-ийн дэглэмд эрс өөрчлөлт гарч, Монгол нь үнэхээр Америкийн буюу түүгээр толгойлуулсан холбоотнуудын “нөлөө”-ний буюу түшиц газар болбол, дээр дурдсанчлан Монголын онцгой геополитикийн байрлалаас шалтгаалсан, хоёр хөрш рүү чиглэсэн, улс төр, цэргийн аюул заналхийлэл бий болж, зарим тохиолдолд төсөөлөхийн аргагүй хэмжээнд байж болох юм. Энэ нь Оросын хувьд түүний Сибирь, Алс Дорнодын чухал бааз, шугам сүлжээг цаг ямагт хяналтад байлгаж, түүний стратегийн орон зайг шахан хумихын зэрэгцээ, шаардлагатай үед тэдгээрийг цохон тасдан, Оросын Алс Дорнодын болон Ази-Номхон далайн бодлогыг сөрөн зогсоож болох юм. Хятадын хувьд мөн адилаар “гурван умард бүс”-ийн чухал бааз, шугам сүлжээг цаг ямагт хяналтад байлгаж, түүний стратегийн орон зайг хумиж шахахын зэрэгцээ шаардлагатай үед баруун тийш гарангуут Шиньжян болон дотор бүсийн харилцааг тусгаарлаж, зүүн тийш хөдлөнгүүт Зүүн Хойд бүс болон дотор бүсийн зам шугамыг тасдан, Хятадын Төв Ази болон Умард чиглэлийн хөгжлийн бодлогыг

²⁵ З.Безинский, “Их шатар-АНУ-ын тэргүүлэх байр суурь түүний гео-стратегийн” [The Grand Chessboard: American Primacy and its Geostategic Imperatives], БНХАУ-ын ОУХ орчуулав, Шанхай-н ардын хэвлэлийн хороо, 1998 он.

сөрөн зогсоох болно. Энэхүү байдал нь Хятадын Зүүн Өмнөт далай тэнгисийн орон зай шахалтад орсон нөхцөлд нэн ноцтой юм.

Орчин үеийн хэсэг орон зайны дайнд моторжсон том армийн бүлэглэлийн дайны онол нэгэнт цагаас хоцорсон ч дохионы мэдээллийн тандах болон пуужингийн стратегийн сүрдүүлэг хийх талаарх Монгол Улсын байршлын ач холбогдол буурсан биш харин нэмэгдсээр байна. Учир нь хэрэв Америк Монголын нутаг дэвсгэрт газрын гадаргуугийн дохионы тандалтын бааз байрлуулбал, түүний одооны байгаа Аляск, Алеутиан/Aleutian/ арал, Япон, Төв Ази, Европ гэсэн газрын гадаргууны дохионы тандалтын баазын системд жинтэй нэмэр болж, Хятад болон Оросыг хайн тандах үр бүтээмж болон нарийвчлалын хэмжээг ихээр дээшлүүлнэ. Хэрэв Монголд цэргийн бааз байгуулж, хэсэг РТУ арми болон дунд зайн пуужин байрлуулбал, ЗХА, ЗА, ТА-ийн бүс нутагт стратегийн сүрдүүлгийн үүрэг гүйцэтгэж болох юм.

Энд тусгай сэдвээр таамаглал анализ хийж байгаа нь зөвхөн онолын хувьд иймэрхүү тохиолдол оршиж байгааг онцолж байгаа хэрэг юм. Үнэндээ Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого нь эвсэлд үл нэгдэх, олон тулгуурт, тэнцвэртэй, төвийг сахих бодлого болон хоёр хөршийн тэргүүлэх чиглэлийн бодлогын дараах хоёрдугаар түвшний бодлого байж, түүний хэрэгжилт нь зорих хүрээнд байх учиртайгаас иймэрхүү байдал үүсэх боломж зөвхөн түүний гадаад бодлогын үзэл баримтлалд эрс өөрчлөлт орсон үед л сая байж болно.

Дэлхийн хэмжээний хоёрхон том хөрштэй Монгол Улс түүний үндэсний аюулгүй байдал, хувь заяа нь хоёр хөршөөс ихээхэн хамааралтай байдгийг сайн мэдэхийн хамт, одоохондоо Хятад-Монгол, Монгол-Орос, Хятад-Оросын харилцаа түүхийн хамгийн таатай үедээ байж, Хятад, Монгол, Оросын төрийн тэргүүний уулзалтын механизм бүрэлдэн тогтож, “гурван улсын эдийн засгийн бүс” байгуулах явц нэгэнт төлөвлөгөөний шатанд хэрэгжиж байгаа нь гурван улсын аюулгүй байдал, хөгжлийн нийтлэг чиг хандлагыг тодорхойлж, иймэрхүү байдал үүсэх нөхцөл боломжийг урьд өмнө байгаагүй түвшинд хүртэл арилгасан байна. Монгол Улсын эхлүүлээд байгаа мөнх төвийг сахих статусын бодлогын эрх зүйн орчныг баталгаажуулах үйл явц нь түүхэн сургамж болон одооны дэлхийн улс төрийн байдлаас үүдэлтэй юм. Энэ нь Монгол Улсын аюулгүй байдал, хөгжил болон бүс нутгийн тогтвортой байдал, хамтын хөгжилд эергээр нөлөөлөх хандлагатай байна.

3. Хаагдмал байдалтай эдийн засаг

Энэ бол Монгол Улсын геополитикоос үүдэлтэй эдийн засгийн хөгжлийн уламжлалт онцлог мөн. Монгол Улсын сүүлийн үеийн түүхэн хөгжлийн үйл явцаас хархад, түүний улс төрийн тогтолцоо, эдийн засгийн хөгжил, нийгмийн бүх салбарын ахиц дэвшил нь хоёр хөршийн нөлөөнд гүнзгий орсон байдаг. Хүйтэн дайны ихэнх хугацаанд Монгол нь Зөвлөлтийн шууд хамааралд оршиж, өмнөд хөршийн харилцаа зогсонги байдалд орж, ЭЗХТЗ-ийн түүхий эд болон мал аж ахуйн бүтээгдхүүний нийлүүлэгч орны хувиар, бараг л дэлхий нийтийн “орхигдсан

арал” болж хоцров. Зөвлөлтийн шууд хамаарал доорх 70 гаруй жил болон хэдэн үеийн нийгмийн элитүүд үндсэндээ Зөвлөлт болон Зүүн Европын орнуудад боловсрол эзэмшсэн зэрэг нь Монголын нийгмийн хөгжлийн чиг хандлагад шууд тусгагдаж, ТУХН болон Зүүн Европын ихэнх орнуудын хамт “цочир эмчилгээ”-гээр шилжилтийн үйл явцаа эхлүүлсэн байна.

Шилжилтийн эхний үед, тогтолцооны огцом хувиргалтын дотоод үрэлт, гадаад тусламж зогсонги байдалд орсон зэрэг нь угаас сул байсан эдийн засгийн нөхцөл байдлыг эрс муутгаж эдийн засгийн бүх салбарууд уналтад оров. Зөвлөлтийн нөлөөний хоосрол хийгээд шилжилтийн хүнд хэцүү нөхцөл байдал бий болсон нь “гуравдагч хөрш”-ийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх үйл явцыг түргэсгэж, Япон, Америк зэрэг өрнийн улсууд, олон улсын банк санхүүгийн байгууллагуудаар голлосон хандив тусламж нь Монголын шилжилтийн эхний хүндрэлтэй үеийг даван туулахад чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Гэсэн хэдий ч мөнхийн хөршийн геополитик, гео-эдийн засгийн барилдлага нь Монголыг орхигдуулж болдоггүйгээс, шилжилтийн хүнд хэцүү үеэс саяхан ангижирсан Орос нь 11 тэрбум ам.долларын их өрийг чөлөөлж, түүний дараа хандив, тусламжаа нэмэгдүүлсээр байна. Шинэчлэл нээлтээр эрчимтэй хөгжиж байсан Хятад аль эхнээс тусламжийн гараа сунган, сүүлийн жилүүдэд тусламжийн хэмжээгээ эрс нэмэгдүүлж одоо нэгэнт хамгийн их хандивлагч орон болсон байна. Энэ бол гео-байршил дах хятад үгийн “холын хамаатан ойрын хөршийг хүрэхгүйн” нийтлэг тайлбар мөн.

Монголын хувьд хоёр хөршийн хүчин чадал харьцангуй тэнцвэртэй бөгөөд ашиг сонирхолын нийтлэг тал олширох тусам тэр нь хөгжлийн алтан үе болдог. Хэрэв бүс нутгийн улс орнуудын нийтлэг эрх ашиг улам бүр нэмэгдэж ямар нэг хэлбэрийн интеграци бий болж, цаашлаад дээд түвшний “ЕХ” шиг хамтын нийгэмлэг бий болбол, энэ нь Монголын хөгжлийн алмазын үе болдог. Тухайн үед үйлдвэрлэлийн хүчин зүйлс бүс нутгийн хүрээнд чөлөөтэй шилжиж, Монголын бүтээгдэхүүний гүйлгээний зардал ихээр хэмнэгдэн, бүс нутаг цаашлаад дэлхий дахины эрдэс баялаг, эрчим хүчний, байгалийн цэвэр бүтээгдэхүүний жинхэнэ нийлүүлэгч, жуулчдыг татах том гүрэн болж болох юм. Үүний зэрэгцээ, эдийн засгийн интеграци нь бүс нутгийн улс орны бүх салбарын нийтлэг эрх ашгийн шүтэлцээг гүнзгийрүүлж, бүс нутгийн энх тайван болон цэцэглэлийг бий болгох хандлагатай. Иймээс энэ нь Монголын төдийгүй бүс нутгийн мөрөөдөл гэж хэлж болох үйл явц юм. Харин хоёр хөршийн хүчний тэнцвэр алдагдаж, зөрчил маргаан хурцадсан тохиолдолд Монгол нь хагас тусгаарлагдмал буюу тусгаарлагдмал байдалд орж, түүний хөгжил нь бүрхэг эсвэл харанхуй үедээ буцах юм. Өөрийн аюулгүй байдал болон хөгжлийн энэхүү эмзэг байдлыг сайн ойлгодог Монгол нь хоёр хөрш үүрд хүчний тэнцвэрээ хадгалж, нийтлэг эрх ашгаа нэмэгдүүлээсэй гэж хүсэх нь мэдээж. Мөн аль нэг хөршид дотоодын үймээн самуун үүсэхийг хүсэхгүй нь лавтай. Учир нь тэдгээр үймээн самуун нь хүн ам цөөнтэй, өөрийгөө хамгаалах чадавхи сул Монголд маш их дарамт, цохолт учруулж мэдэх юм.

Монгол Улсын хөгжлийн дотоод нөхцөлөөс үзэхэд, эдийн засгийн хөгжлийн сул байдал, эдийн засгийн бүтцийн дан цулгүй байдал, бүтээгдэхүүний бүтцийн

анхдагч байдал, хөрөнгө болон технологийн хомс байдал, дэд бүтцийн сул байдал, байгаль цаг уурын эрс тэс байдал, геополитикийн эмзэг байдал, улс төрийн тогтолцооны боловсронгуй бус байдал, газар зүйн тусгаарлагдмал байдлын хэрээр, бүс нутаг болон олон улсын эдийн засгийн эргэлтэд оролцох бэрхшээл, зардал их байж, үүнээсээ шалтгаалан өнөөдрийг хүртэл эдийн засгийн гадаад харилцаанд хоёр хөрш нь зонхилж байна. Монгол Улс далайн гарцгүй нь түүний геополитик, гео-эдийн засгийн нийтлэг дутагдал болж Монгол нь хялбар, хөнгөлөлттэй, олон далайн гарц олохын төлөө урт хугацаа шаргуу хүчин чармайлт гаргасан хэдий ч олон хүчин зүйлийн улмаас гийм сайн үр дүнд хүрээгүй. Харин 2014 оны 8-р сард БНХАУ-ын дарга Ши Жиньпинээс Монгол Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр үзэглэсэн “хамтарсан тунхаглал”-д, хоёр тал яриа зөвшилцлөөр дамжин 1991 оны “Монгол Улс Хятадын нутаг дэвсгэрээр дамжин далайд нэвтрэх болон дамжин өнгөрөх тээврийн хэлэлцээр”-г өөрчлөлт оруулах, Монголд дамжин өнгөрөх тээврийн нэн таагай нөхцөл хангах, энэ хүрээнд Хятадын Хойд, Зүүн хойд бүсийн нээлттэй далайн портыг Монгол Улсад ашиглуулхаар зарлав. Энэ бол өнөөдөр хүртэлх хөрш орноос Монголд олгосон хамгийн тааламжтай нөхцөл болно. Мөн ч Ши Жиньпиний “дотно, итгэмжтэй, хүртээмжтэй, хүлцэлтэй” хөршийн бодлогын бодит илрэл мөн.

4. Шинээр хөгжсөн эрдэс баялаг, эрчим хүчний нийлүүлэгч том орон

Монгол Улс нь ашигт малтмалын нөөц, агууламж, олборлох нөхцөл, лицензийн үнэ, зах зээлийн зай зэргээр өөрийн давуу талтай юм. Монгол Улсын Засгийн газрын мэдээллийн албаныхны мэдээлснээр, одоогийн Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн нийт дүн дэлхийд 7-рт эрэмбэлэгдэж, 80 гаруй төрлийн 1470 ашигт малтмалын орд, 8240 илрэлийг хайн тогтоосон байна²⁶. Иймээс Монгол Улсыг уламжлалт нөөц нийлүүлэгч Австрали, Бразил, Энэтхэг, Орос, Персийн булангийн орнуудын дараах шинээр бий болж байгаа нөөц нийлүүлэгч том орон гэж хэлэх бүрэн үндэслэлтэй юм.

Монгол Улсын 2014 оны 9-р сарын 1 хүртэлх гол болох ашигт малтмалын нөөцийн хэмжээ²⁷ болон 2014 оны эцсийн экспортын хэмжээ²⁸ нь: (1) Зэс: нэгэнт 57 орд, 1180 илрэл тогтоож, зэсийн хүдрийн нөөц (A+B+C) 85.7 сая тонн, зэсийн хүдрийн илрэлийн тооцоолсон нөөц (P) 93.3 сая тонн байж, Азид 1-рт байрлана. 2014 онд 1.37 сая тонн зэсийн баяжмал, 5000 тонн катодын зэс экспортлов. (2) Нүүрс: нэгэнт 160 орд, 270 илрэл тогтоож, түүний геологийн тооцоолсон нөөц (P) 173.3 тэрбум тонн, нарийвчилсэн нөөц (A+B+C) 26.8 тэрбум тонн, дэлхийд 10-рт орно. 2014 оны экспортын хэмжээ 20 гаруй сая тонн. (3) Төмрийн хүдэр: нэгэнт 71 орд, 500 гаруй илрэл тогтоож, нөөц 1.65 тэрбум тонн, 2014 оны экспорт 6.32 сая тонн. (4) Алт: нэгэнт алтны 117 үндсэн орд, 664 шороон орд, 1763 илрэл тогтоов. Үүнд ордын нөөц (A+B+C) 2700 тонн, илрэлийн тооцоолсон нөөц (P) 1830 тонн,

²⁶ Батлагдсан “ашигт малтмалын биржийн тухай хуулийн үзэл баримтлал”, <http://olloo.mn/n/19992.html>

²⁷ Монголын ашигт малтмалын газар, 2014 оны эхний хагасын геологийн мэдээллийн эмхэтгэл, <http://mram.gov.mn/>, 2015.03.22;

²⁸ Монгол улсын гаалийн ерөнхий газар, www.ecustoms.mn

дэлхийд 10-рт байрлана. 2014 онд 10 тонн алт экспортлов. (5) Жонш: нэгэнт 171 орд, 158 илрэл тогтоож, ордын нөөц (А+В+С) 47.95 сая тонн, илрэлийн тооцоолсон нөөц (Р) 33.4 сая тонн. 2014 онд 310 мян.тонн жоншны баяжмал экспортлож, дэлхийд үйдвэрлэлийн хэмжээгээр 3-рт, экспортын хэмжээгээр 2-рт байрлана. (6) Хар тугалга, цайр: 18 хар тугалгын орд, 158 хар тугалгын илрэл тогтоож, ордын нөөц (А+В+С) 2.07 сая тонн, илрэлийн тооцоолсон нөөц (Р) 30 мян.тонн. 24 цайрын орд, 110 цайрын хүдрийн илрэл тогтоож, ордын нөөц (А+В+С) 6.2 сая тонн, илрэлийн тооцоолсон нөөц (Р) 61 мян.тонн. 2014 онд 100 гаруй мян.тонн цайрын баяжмал экспортлов. (7) Газрын тос: хэтийн төлөвийн нөөц 3 тэрбум баррелиас багагүй. Одооны түүхий газрын тосны олборлолт болон экспорт 5 сая гаруй баррель байна. (8) Фосфорын хүдэр: нэгэнт тогтоосон нөөц (А+В+С) 6 тэрбум тонн, Азид 1-рт, дэлхийд 5-рт байрлана. (9) Газрын ховор элемент: хэтийн төлөвийн нөөцөөр дэлхийд дээгүүр байрлана. (10) Ураны хүдэр: урьдчилсан хайгуулаар тогтоосон нөөц 1.4 сая тонн гаруй, дэлхийн эхний 10-т байрлана.

Хүснэгт 1

**Монгол Улсын 2013-2014 оны уул уурхайн бүтээгдэхүүний
экспортын хэмжээ (гол улсаар)**

Уул уурхайн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2013		2014	
		Экспортын хэмжээ	Экспортын үнэ	Экспортын хэмжээ	Экспортын үнэ
1. жонш, жоншны баяжмал	мян.тонн, мян. ам.дол	337.7	83204.7	313.3	71360.6
Хятад	мян.тонн, мян. ам.дол	163.6	41831	128.2	32572.5
Орос	мян.тонн, мян. ам.дол	170.1	39807.3	179.5	37424.8
2. төмрийн хүдэр, төмрийн нунтаг	мян.тонн, мян. ам.дол	6724.5	654333	6324.5	446363.7
Хятад	мян.тонн, мян. ам.дол	6724.5	654333	6324.5	446363.7
3. зэсийн баяжмал	мян.тонн, мян. ам.дол	649.8	948900.9	1378.1	2573621.8
Хятад	мян.тонн, мян. ам.дол	649.8	948900.9	1373.4	2560729.3
Япон	мян.тонн, мян. ам.дол			4.7	12892.5
4. цайрын хүдэр, цайрын баяжмал	мян.тонн, мян. ам.дол	130.9	119084.6	99.4	113167.3
Хятад	мян.тонн, мян. ам.дол	130.9	119084.6	99.4	113167.3
5. цагаан тугалгын хүдэр	тун, 千美元 тонн, мян.ам.дол	120.5	1214	120.2	1029.5
Хятад	тонн, мян.ам.дол	66.5	649.3	0.2	1.1

Малайз	тонн, мян.ам.дол	54	564.7	119.9	1028.4
6. Гянт болдын хүдэр, гянт болдын баяжмал	тонн, мян.ам.дол	417.5	6098.3	1519.6	19588.5
Хятад	тонн, мян.ам.дол	398	5850.7	708.6	7862.8
Орос	тонн, мян.ам.дол	10	80	79.7	690.7
Нидерланд	тонн, мян.ам.дол			49.9	1217.8
Америк	тонн, мян.ам.дол	9.5	167.6	264.7	4401.6
Герман	тонн, мян.ам.дол			35	594.9
Сингапур	тонн, мян.ам.дол			139.8	2405.8
Вьетнам	тонн, мян.ам.дол			241.9	2921.8
7. Молибдений хүдэр, молибдений нунтаг	тонн, мян.ам.дол	3878.7	28648.6	4030.5	35677.2
Хятад	тонн, мян.ам.дол	2132.5	15555.9	3170.3	26360.1
БНСУ	тонн, мян.ам.дол	1177.2	9049.1	682	7862.8
Мексик	тонн, мян.ам.дол	211.3	1682.6		
Хонг Конг	тонн, мян.ам.дол	322.2	2114		
Орос	тонн, мян.ам.дол	35.5	247	142.1	1024.8
Америк	тонн, мян.ам.дол			36	429.5
8. Алт (боловсруулсан болон хагас боловсруулсан)	кг, мян.ам.дол	7558.5	309826.5	10040.8	405244.3
Канад	кг, мян.ам.дол	3561.9	134071.7		
Англи	кг, мян.ам.дол	3996.6	175754.8	9386.9	379965.7
Швейцарь	кг, мян.ам.дол			653.6	25268.5
9. зэс	мян.тонн, мян. ам.доллар	2.2	16136.1	5	33356.9
Хятад	мян.тонн, мян. ам.доллар	2.2	16136.1	5	33356.9
10. нүүрс	мян.тонн, мян. ам.доллар	18188.3	1115982.5	19481.5	848596.9
Хятад	мян.тонн, мян. ам.доллар	18187.7	1115943.5	19461.4	847173.2
Орос	мян.тонн, мян. ам.доллар	0.6	39	20	1423.7

Эх сурвалж: Монгол улсын гаалийн ерөнхий газар, www.ecustoms.mn

“Хятад, Монгол, Оросын эдийн засгийн корридор” байгуулах тохиролцоонд уул уурхай, эрчим хүчний хамтын ажиллагаа нь чухал бүрэлдэхүүн хэсэг байж, сүүлийн үед Хятад, Монголын эрчим хүчний хамтын ажиллагаа улам бүр эрчимжиж, Монгол Улсын энэхүү боломжийн байр суурийг бодит байдал болгоох үйл явцад шинэ түлхэц үзүүлж байна. Үүнээс гадна, Монголын сэргээгдэх эрчим хүчний нөөц дэлхийд дээгүүр байрилж, Хятад, Япон, Солонгос нь тус тусдаа буюу хамтдаа ашиглах төсөл дэвшүүлж, ойрын ирээдүйд хэрэгжих хандлага ажиглагдаж буй.

Уул уурхайн бүтээгдэхүүний, эрчим хүчний зах зээлийн эрэлт хэрэгцээнээс үзэхэд, гол болох зах зээлүүд ихэвчлэн Зүүн Азид төвлөрч, Хятад нь одоогоор нилээд томоохон эрэлт хэрэгцээт улс төдийгүй ирээдүйд урт хугацаанд энэхүү байдлаа хадгалах болно. Мөн Япон, БНСУ чухал хэрэгцээний улс бөгөөд эдгээр улс орон нь Монгол Улсаас ойр оршиж, тус тусын хоёр талын харилцаа хамтын ажиллагаа сайн байж, ашиглах, олборлох, боловсруулах, нийлүүлэх хэтийн төлөв сайнаар төсөөлөгдөж байна.

5. Дамжин өнгөрөх тохиромжтой логистикийн эх хуурайн гүүр зам

Хятадаар төлөөлүүлсэн хуурай зам тээврийн технологийн шинэ ололт, бүс нутгийн интеграцийн чиг хандлага нь Монгол Улсын Хятад Оросын хооронд, Евразийн хооронд орших газар зүйн байршлын чухал ач холбогдолдлыг тодорхойлж байгаа юм. Үүнээс гадна, Монгол Улсын ашигт малтмал, сэргээгдэх эрчим хүчний нөөц асар их, Оросын Сибирь, Алс Дорнод нь дэлхийн хэмжээний байгалийн баялаг ихтэй бүс нутаг бөгөөд Хятад, Оросын эрчим хүчний хамтын ажиллагааны ид хүчтэй явагдаж байгаа нь гурван улсын өөр өөрийн дэвшүүлсэн санаачлага төслийг уялдуулан төлөвлөх шатанд ахиулав. Монголын санаачилсан “Талын зам” нь Хятад, Оросын хооронд орших газар зүйн давуу талдаа суурьлан, төмөр зам, хурдны автозам, газрын тос болон байгалийн хийн дамжуулах хоолой, өндөр хүчдэлийн цахилгаан шугмаар Хятад, Оросыг холбох зорилготой юм. Түүний тодорхой төслүүд гэвэл Хятад, Оросыг холбох 997 км урт хурдны автозам, 1100 км урт өндөр хүчдэлийн шугам, Транс-Монголын төмөр зам, байгалийн хийн дамжуулах хоолой, газрын тос дамжуулах хоолойг барьж байгуулах буюу өргөтгөх ажил байж, урьдчилсан байдлаар, нийт 50 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардагдах юм байна²⁹.

2014 оны 9-р сарын 11-ний Душанбегийн Хятад, Монгол, Орос гурван улсын төрийн тэргүүний анхдахь уулзалтын үеэр хүрсэн “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор”-ыг хамтаар байгуулах тохиролцоо бол Хятадын “Торгоны замын эдийн засгийн бүс,” ОХУ-ын Транс-”Евразийн төмөр зам\хожим нь Евразийн холбоо\”, Монголын “Талын зам “санаачилгын уялдаа нэгтгэл мөн³⁰. 2015 оны 7-р сарын Уфагийн хоёрдахь уулзалтын үеэр “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридорын хамтын ажиллагааны төлөвлөгөөний хөтөлбөр” боловсруулахыг зарлав³¹.

Зөвхөн гурван улс болон эдийн засгийн зардлын үүднээс үзэхэд, Оросын Сибирээс Хятад хүрэх ямар ч зам тээврийн хэлбэрүүд Монгол Улсаар дамжих нь одооны яригдаж байгаа зүүн болон баруун шугамаас илүү хэмнэлттэй юм.

2014 оны 11-р сарын 8-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж АПЕК-ийн “дэд бүтцийн түншлэлийн харилцаагаа бэхжүүлэх уулзалтад” оролцох үеэр

²⁹ Зөвхөн нэг л төмөр замын боомтоор Хятад зүг зөөвөрлөдөг, Монгол “талын замаа” яаравчлан нэвтрүүлэхийг хүсч байгаа, “лавлах сонин” http://www.guancha.cn/Neighbors/2015_07_10

³⁰ Ши Жиньпин: Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор байгуулах, ардын сүлжээ, 2014.09.12

³¹ Уфагийн дээд уулзалт: Хятад, Монгол, Оросын төрийн тэргүүний хоёр дахь уулзалт: гурван улсын эдийн засгийн коридор байгуулах, http://www.guancha.cn/Neighbors/2015_07_10

хэлэхдээ, Монгол Улс далайд гарцгүй, гэхдээ Ази Европыг холбосон хамгийн ойр зам мөн, одоо Ази, Европ, Хятад, Орос хоорондын худалдаа ид эрчимжиж буй, Монгол Улс өөрийн газар зүйн давуу талаа ашиглавал зөвхөн Хятад, Орос хоорондын худалдаа, тээвэрлэлтэд хялбар дөхөм үзүүлэх төдийгүй, Хятад, Оростой хамтран Евразийн тээврийн коридорыг Монголд байгуулах хүсэлтэй бөгөөд бүс нутгийн логистикийн сүлжээнд идэвхтэй оролцох хүчин цармайлт хийж байна. Монгол Улс нэгэнт НҮБ-ын Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн комиссийн хэрэгжүүлж байгаа Азийн авто замын сүлжээ, дамжин өнгөрөх төмөр замын сүлжээний төсөлд нэгдэж, Монгол Улсын хил дэх Азийн АНЗ, АН32 болон АН4 хурдны автозамын сүлжээний бүтээн байгуулалтын талаар идэвхтэй ажиллаж байна. “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны буудлын төслийг” нэгэнт эхлүүлж, 2016 онд ашиглалтад оруулхаар төлөвлөж байна. Тус онгоцны буудал ашиглалтад орхоор Монгол нь Евразийн дамжин өнгөрөх тээврийн зангилаа болж болох юм³² гэжээ.

Евразийн далай хуурайн хамтарсан тээврийн талаар, одоохондоо ТяньЖин боомт бол Монгол Улсын хамгийн ойр далайн гарц мөн. БНХАУ-ын дөрвөн Транс тээврийн нэг болох ТяньЖин-Монголын Евразийн хамтарсан тээврийн их зам (бас Тяньжин төсөл гэдэг) нь ТяньЖины ШиньГанаас Бээжин, ДаТун, Эрээнийг дамжин Монголд орж, Улаанбаатар, Алтанбулгаас умард ОХУ-ын Транс-Сибирийн төмөр замаар Брестэд хүрч дахин ачаалж, баруун тийш Роттердам боомтод хүрдэг. Тус чиглэлийн тээвэр нь Кейп чиглэлийнхээс 1/2 гаруй зай хэмнэж, Суэцийнхээс 1/3 зай, 35 хоногийн хугацаа, 20-25% тээврийн зардал хэмнэх юм байна³³.

Одоохондоо ТяньЖин-Монгол Улсын хамтын ажиллагаанд шинэ ахиц гарч, Тяньжин болон Монгол Улсын хооронд ТяньЖины БиньХай Шинэ дүүргийн ДүнЖян гаалийн баталгаат бүсийн 10 га газарт 50 жилийн хугацаатай “ЖиньМэн тээврийн логистикийн төсөл” хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурсан байна³⁴.

Монголын төмөр замаар жишээлэхэд, одоо Оростой хоёр шугамаар, Хятадтай нэг шугамаар холбогдож буй бөгөөд байгуулж байгаа буюу төлөвлөж байгаа нь Оростой нэг шугамаар, Хятадтай гурван шугамаар холбогдох болно. Үүнд, 2014 оны 10-р сарын 24-д Монгол Улсын ИХ-аар батлагдсан, төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн зарим арга хэмжээний тухай тогтоолд, Таван толгой-Гашуунсухайт, Хөөт-Бичигт чиглэлд нарийн царигийн төмөр зам тавих болов. Үүнд Таван толгой-Гашуунсухайт төмөр замын газар шорооны ажил нэгэнт дуусгавар шатандаа байна. Нөгөө нэг нөөц баялгийн тээвэрлэлтийн шугам болох Хөөт-Бичигтийн төмөр зам нь, ЖиньЗү далайн боомтын ашиглах асуудал нэгэнт шийдэгдсэнээс удахгүй эхлэх төлөвтэй байна. Төлөвлөгдөж байгаа Чойбалсангаас (эсвэл Хөөт) ЖиньЗү хүртэлх төмөр замын нийт урт 1200 гаруй км. Үүнд Чойбалсан (эсвэл Хөөт)-Бичигтийн замын урт 420 км, БНХАУ-ын хил дэх замын урт 850 км,

³² Зөвхөн нэг л төмөр замын боомтоор Хятад зүг зөөвөрлөдөг, Монгол “талын замаа” яаравчлан нэвтрүүлэхийг хүсч байгаа, “лавлах сонин” http://www.guancha.cn/Neighbors/2015_07_10

³³ Олон улсын мултимодаль тээвэр, хуухайн тээврийн _ Baidu номын сан, <http://wenku.baidu.com/>

³⁴ Монголын төмөр зам, <http://www.mtz.mn>

хоёр шугамын сонголттой. Тус төмөр зам нь Чойбалсан-Эрэнцавын төмөр замаар ОХУ-ын Транс-Сибирийн төмөр замд нэвтрэх болно. Тус шугамын дагуу нөөц баялаг ихтэй Өвөр Монголын зүүн, дунд бүс, Монгол Улсын зүүн бүс, Оросын Сибирь хамрагдан, Манжуураар дамжин ДаЛянь боомт хүрэхээс 900 гаруй км зай хэмнэж, Улаанбаатараас Эрэн-хотыг дамжин ТяньЖинь хүрэхээс 800 гаруй км зай хэмнэх тул чухал ач холбогдолтой. Монголын тал концессийн, ВОТ, АДБХОБ-ны шугам буюу “нөөцөөр төсөл солих” хэлбэрээр хэрэгжүүлж болох юм³⁵.

Хуурайн зам тээврийн инноваци технологи, Монгол Улсын тохиромжтой газар зүйн байршил, Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор байгуулах үйл явц нь Монгол орныг Хятад, Оростой, Ази Европыг холбосон өрсөлдөх чадвар бүхий ложистикийн эх газрын гүүр, коридор болгох ирээдүйн төлөвийг тодорхойлсон байна.

НОМ ЗҮЙ

1. З.Бжезинский, “Их шатар-АНУ-ын тэргүүлэх байр суурь түүний гео-стратегий” The Grand Chessboard: American Primacy and its Geostrategic Imperative, БНХАУ-ын ОУХ орчуулав, Шанхайн ардын хэвлэлийн хороо, 1998 он.
2. Батлагдсан “ашигт малтмалын биржийн тухай хуулийн үзэл баримтлал”, <http://oloo.mn/n/19992.html>.
3. Монголын ашигт малтмалын газар, 2014 оны эхний хагасын геологийн мэдээллийн эмхэтгэл, <http://mram.gov.mn/>, 2015.03.22.
4. Монгол улсын гаалийн ерөнхий газар, www.ecustoms.mn
5. Зөвхөн нэг л төмөр замын боомтоор Хятад зүг зөөвөрлөдөг, Монгол “талын замаа” яаравчлан нэвтрүүлэхийг хүсч байгаа, “лавлах сонин” http://www.guancha.cn/Neighbors/2015_07_10
6. Ши Жиньпин: Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор байгуулах, ардын сүлжээ, 2014.09.12
7. Уфагийн дээд уулзалт: Хятад, Монгол, Оросын төрийн тэргүүний хоёр дахь уулзалт: гурван улсын эдийн засгийн коридор байгуулах, http://www.guancha.cn/Neighbors/2015_07_10
8. Олон улсын мултимодаль тээвэр, хуухайн тээврийн Baidu номын сан, <http://wenku.baidu.com/>
9. Монголын төмөр зам, <http://www.mtz.mn>
10. Б.Хөгжилт, БНХАУ, Монгол улсыг төмөр замаар холбох бодлого, үйл явцад хийсэн дүн шинжилгээ, “Олон улс судлал” 2014.№3

³⁵ Б.Хөгжилт, БНХАУ, Монгол улсыг төмөр замаар холбох бодлого, үйл явцад хийсэн дүн шинжилгээ, “Олон улс судлал” 2014.№3

